



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/543

Есөнбулаг

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ГААОНӨГ/202312007 дугаар бүхий Жимсний суулгац нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------------|---------------|---|
| Ажлын хэсгийн дарга: | Т.Сүхбаатар | (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Гишүүд: | Г.Төгсбилэг | (Хүнс, хөдөө аж ахуйн газрын ургамал хамгааллын хяналтын ахлагч байцаагч) |
| | Ж.Билэгсайхан | (Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн) |
| | Х.Нордогбат | (Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | С.Баярмаа | (Хүнс, хөдөө аж ахуйн газрын нярав) (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |

2.Жимсний суулгацыг гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, сумдад захиалгын дагуу хуваарилан олгож, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Р.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

